



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2020 оны 06 сарын 17 өдөр

Дугаар

А/334

Улаанбаатар хот

Эмнэлгийн бие даасан байдлыг
хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Эмнэлгийн бие даасан байдлын хэрэгжилтийг зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг нэгдүгээр, эмнэлгийн бие даасан байдлыг хэрэгжүүлэх зааврыг хоёрдугаар, эмнэлгийн бие даасан байдлын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний жишиг аргачлалыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Я.Амаржаргал)-т үүрэг болгосугай.

САЙД

Д.САРАНГЭРЭЛ

141201121

Эрүүл мэндийн сайдын 2020 оны 01 сарын
17 өдрийн 17 дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт

Эмнэлгийн бие даасан байдлын хэрэгжилтийг зохицуулах
зөвлөлийн бүрэлдэхүүн

Дарга	Эрүүл мэндийн сайд
Нарийн бичгийн дарга	Эмнэлгийн бие даасан байдлыг хэрэгжүүлэх нэгжийн дарга
Гишүүд:	ЭМЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга
	ЭМЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга
	ЭМЯ-ны Эмнэлгийн тусламжийн газрын дарга
	ЭМЯ-ны Эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга
	ЭМЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга
	СЯ-ны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга /зөвшилцсөнөөр/
	СЯ-ны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын Төсвийн зарлагын хэлтсийн дарга /зөвшилцсөнөөр/
	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга
	Нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга
	Төрийн албаны зөвлөлийн төлөөлөл /зөвшилцсөнөөр/
	Үндэсний Аудитын газрын төлөөлөл /зөвшилцсөнөөр/
	МХЕГ-ын Эрүүл мэндийн хяналтын хэлтсийн дарга /зөвшилцсөнөөр/
	Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн төлөөлөл /зөвшилцсөнөөр/

**Эмнэлгийн бие даасан байдлын хэрэгжилтийг зохицуулах зөвлөлийн
ажиллах журам**

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Эмнэлгийн бие даасан байдлын хэрэгжилтийг зохицуулах зөвлөл (цаашид Зөвлөл гэх)- ийн үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

2. Зөвлөл нь Эрүүл мэндийн тухай болон Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн бие даасан байдлыг бэхжүүлэх шинэчлэлийг улсын хэмжээнд мэргэжил арга зүйн нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангана.

Хоёр. Зөвлөлийн эрх, үүрэг

Зөвлөл дараах эрх, үүрэгтэй.

1. Эмнэлгийн бие даасан байдлыг хэрэгжүүлж байгаа эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс сонсгол хэлэлцэж, тусламж, үйлчилгээний чанар сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг сайжруулах чиглэлээр зөвлөмж өгөх;

2. Эмнэлгийн гүйцэтгэх удирдлагаас Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээ болон эмнэлгийн бие даасан байдлын хэрэгжилтийн явцтай биеэр болон тайлагналтын хэлбэрээр танилцах, холбогдох шийдвэр гаргах;

3. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжид хийсэн хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнтэй танилцах, холбогдох чиглэлээр зөвлөмж гаргах;

4. Төлөөлөн Удирдах Зөвлөл, Эмнэлгийн гүйцэтгэх удирдлагаас шаардлагатай мэдээ, мэдээлэл гаргуулж авах;

5. Салбарын хэмжээнд эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа бодлого, зарчмыг тухайн эмнэлэгт хэрэгжиж байгаа эсэхэд хөндлөнгийн багаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэх;

6. Төрийн болон орон нутгийн өмчит эмнэлгийн бие даасан байдлыг бэхжүүлэх шинэчлэлийг хэрэгжүүлэхэд бусад салбар болон байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог хангах, харилцан мэдээлэл солилцох;

7. Шаардлагатай хууль эрх зүйн орчин бүрдүүлэх, дүрэм журамд өөрчлөлт оруулах асуудлаар зөвлөмж, шийдвэр гаргах.

Гурав. Зөвлөлийн зохион байгуулалт

1. Зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр нь хуралдаан байна. Зөвлөл хэлэлцсэн асуудлаараа холбогдох зөвлөмж, шийдвэр, дүгнэлт гаргана.

2. Зөвлөл улиралд 1 удаа хуралдах бөгөөд шаардлагатай тохиолдолд Зөвлөлийн даргын шийдвэрлэснээр ээлжит бусаар хуралдаж болно.

3. Зөвлөлийн хурал гишүүдийн ердийн олонхи хүрэлцэн ирснээр хүчин төгөлдөрт тооцогдох бөгөөд асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн ердийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Санал тэнцсэн тохиолдолд асуудлыг хурал даргалагчийн саналаар шийдвэрлэнэ.

4. Зөвлөлийн хуралдааныг танхимаар болон цахимаар зохион байгуулна.

5. Зөвлөлийн ажлын алба нь ЭМЯ-ны дэргэдэх “Эмнэлгийн бие даасан байдлыг хэрэгжүүлэх” нэгж байна.

6. Ажлын алба нь зөвлөлөөс гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийн явцыг зөвлөлд танилцуулна.


7. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь ЭМЯ-ны дэргэдэх “Эмнэлгийн бие даасан байдлыг хэрэгжүүлэх” нэгжийн дарга байна.

8. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь зөвлөл хуралдахаас ажлын 5 хоногийн өмнө Зөвлөлийн гишүүдэд хурлын холбогдох материалыг цахимаар хүргүүлсэн байна.

9. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь хурал хуралдсанаас хойш ажлын 3 хоногт багтаан хурлын протокол, шийдвэрийг Зөвлөлийн даргаар баталгаажуулан холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.

Эрүүл мэндийн сайдын 2020 оны 08 сарын
17 өдрийн 11334 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

Төрийн болон орон нутгийн өмчийн төрөлжсөн мэргэшлийн болон
нэгдсэн эмнэлгийн бие даасан байдлыг хэрэгжүүлэх
заавар



Нэг. Ерөнхий зүйл

Энэхүү зааврын гол зорилго нь Төрийн болон орон нутгийн өмчийн төрөлжсөн мэргэшлийн болон нэгдсэн эмнэлэгт эмнэлгийн бие даасан байдлыг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл, үйл ажиллагааг тодорхойлоход оршино.

Эмнэлгийн бие даасан байдлыг хэрэгжүүлэх зорилт

1. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-д эмнэлгийн засаглах эрхийг шилжүүлэх замаар шийдвэр гаргалт, тусламж, үйлчилгээнд тавих хяналт, үйл ажиллагааны зохицуулалтад өмчлөгч болон санхүүжүүлэгч байгууллага, эмнэлгийн ажилтан болон үйлчлүүлэгчдийн төлөөллийг оролцох боломжийг бүрдүүлэх;

2. Төрийн өмчит эмнэлгүүд өөр хоорондоо болон хувийн хэвшлийн эмнэлгүүдтэй өрсөлдөх боломжийг нэмэгдүүлэх;

3. Эмнэлгийн удирдлагын санхүүгийн бие даасан чадавхийг бэхжүүлэх, эмнэлгийн тусламжийн үргүй зардлыг бууруулах, чанар, хүртээмж, үр дүнтэй тусламж, үйлчилгээ үзүүлэх боломжийг нэмэгдүүлэх;

4. Эмнэлгийн удирдлагын хүний нөөцийн бие даасан чадавхийг бэхжүүлэх, гүйцэтгэлд суурилсан цалин, урамшууллын тогтолцоо бүрдүүлж эмнэлгийн ажилтны гүйцэтгэлийг сайжруулах, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх;

5. Эмнэлгийн гүйцэтгэлийн удирдлагыг сайжруулж тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, үр дүн, үр ашгийг нэмэгдүүлнэ.

Эмнэлгийн бие даасан байдлыг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

Эмнэлгийн бие даасан байдлыг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.

Үүнд:

- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж, үр дүн, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэгдсэн байх;

- Иргэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахтай холбоотой үүсэх санхүүгийн эрсдлээс хамгаалах;

- Эмнэлгийн санхүүжилтийг (улсын төсвийн, эрүүл мэндийн даатгалын) бууруулахгүй байх;

- Эмнэлгийн орлогыг нэмэгдүүлэх, ажилтны цалин, урамшууллыг нэмэх зорилгоор төлбөртэй тусламж, үйлчилгээнд хэт анхаарахгүй байх зэрэг болно.

Чиглэл	Бие даасан байдал 5-10 жилд	Өнөөгийн нөхцөл байдал	Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл, үйл ажиллагаа
Үндсэн чиглэл 1: Засаглал ба зохицуулалт			
1.1 Засаглал	<p>1.1.1 Салбар хоорондын хамтын ажиллагаа Хамтран ажиллагч төрийн байгууллагууд Эмнэлгийн бие даасан байдлыг хэрэгжүүлэх чиглэлээр нэгдсэн ойлголттой болж үйл ажиллагааны уялдаа холбоо жигдэрсэн байна.</p> <p>Хууль эрх зүйн баримт бичгүүд нь бие даасан байдлыг дэмжих чиглэлээр хоорондоо уялдсан байна.</p> <p>Эмнэлгийн бие даасан байдлын удирдлага, санхүүжилтийн оновчтой арга хэрэгслийг ашигласан байна.</p>	<p>Эмнэлгийн бие даасан байдлыг хэрэгжүүлэх зорилгыг хэрэгжүүлэх шинэчлэлийн талаар хамтран ажиллагч байгууллагууд (СЯ, МХЕГ, Үндэсний аудит г.м)-ын нэгдсэн ойлголт хангалтгүй байна.</p>	<p><u>Салбар хоорондын хамтын ажиллагаа</u> Эмнэлгийн бие даасан байдлыг хэрэгжүүлэх чиглэлээр төрийн байгууллагууд хоорондоо мэдээлэл солилцох, хамтын шийдвэр гаргах механизм бий болгоно. Үүний тулд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд Эмнэлгийн бие даасан байдлын хэрэгжилтийг зохицуулах зөвлөл, Аймаг, нийслэлийн түвшинд салбар зөвлөл байгуулна.</p> <p><u>Мэдээлэл солилцох</u> Хамтран ажиллагч талууд шаардлагатай мэдээ, мэдээллийг хоорондоо солилцон ажиллана. Шаардлагатай мэдээллийн жагсаалт, мэдээлэл солилцох давтамж, мэдээллий урсгал, эргэн мэдээллийн зохицуулалт тодорхой болсон байна.</p> <p><u>Хууль, тогтоомж, стандарт:</u> Эмнэлгийн бие даасан байдалтай холбогдох хууль эрх зүйн баримт бичгийн (дүрэм, журам, стандарт) хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, шаардлагатай өөрчлөлтийг цаг тухайд нь хийнэ. Хяналт-шинжилгээ, үнэлгээнд тухайн эмнэлгийн удирдах ажилтан, мэргэжлийн нийгэмлэг,</p>

			<p>холбоо, төрийн байгууллагуудын төлөөллийг татан оролцуулна.</p> <p>ЭМЯ (холбогдох байгууллага)-д Эмнэлгийн засаглал, бие даасан байдлыг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг зохицуулах нэгж байгуулагдсан байна.</p>
<p>1.1.2 Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/</p> <p>Эмнэлгийн засаглах удирдлага нь байнгын тогтвортой үйл ажиллагаа бүхий Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) байна. ТУЗ-ийн гишүүд нь төлөөлж буй талууд (өмчлөгч, эмнэлгийн ажилтан, үйлчлүүлэгч)-ын эрх ашгийг хамгаалах талаар зохих мэдлэг, ур чадвар, туршлагатай байна. ТУЗ-ийн гишүүд тогтвортой байж үйл ажиллагаанд тасралтгүй, идэвхтэй оролцох нь эмнэлгийн засаглалыг амжилттай хэрэгжүүлэх үндэс болно.</p> <p>ТУЗ болон эмнэлгийн гүйцэтгэх удирдлагын үүрэг, хариуцлага хоорондоо тодорхой зааг, ялгаатай байна.</p> <ul style="list-style-type: none"> - Эмнэлгийн удирдлагын баг нь эмнэлгийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна. - ТУЗ нь тухайн эмнэлгийн хөгжлийн стратеги, зорилт, үйл ажиллагааны гүйцэтгэл нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт, хэрэгцээнд нийцэж байгаа эсэхэд хяналт тавина. 	<p>Эрүүл мэндийн болон Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулиар эмнэлгийн ТУЗ-ийн бүрэлдэхүүн, үүрэг, хариуцлагыг тодорхой хуульчилсан. Хуулийн хэрэгжилтийн хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчит нэгдсэн эмнэлгийн ТУЗ-ийн үйлгэрчилсэн дүрмийг Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/467 дугаар тушаалаар баталсан. Дүрмээр эмнэлгийн бие даасан байдлыг хэрэгжүүлж байгаа эмнэлгийн ТУЗ-ийн гишүүд харилцан зөвшилцөж "ТУЗ-ийн дүрэм"-ээ боловсруулж мөрдөх үүрэгтэй.</p> <p>Эмнэлгийн бие даасан байдлыг бэхжүүлэх зорилгоор АХБ-ны дэмжлэгтэй Эмнэлгийн бие даасан байдлыг бэхжүүлэх "ТА-9037 МОН" төслийг 2017-2019 онд хэрэгжүүлсэн. Төслийн хэрэгжилтийн явцад дараах сургамжтай талууд гарсан. Тухайлбал,</p> <ul style="list-style-type: none"> - ТУЗ-ийн гишүүд тогтворгүй үе үе солигдох, Ялангуяа өмчлөгчийг төлөөлж буй ЭМЯ, СЯ, ЭМДЕГ-аас томилогдсон гишүүний албан тушаал өөрчлөгдөхөд тухай бүрт солигдох; - Байгууллагын удирдлагын менежмент, зохион байгуулалтын талаар ТУЗ-ийн гишүүдийн мэдлэг, ур чадвар, туршлага хангалтгүй байх. - Урамшуулал олгохгүй байгаагаас ТУЗ-ийн 	<p><u>ТУЗ байгуулах:</u></p> <p>Бие даасан эмнэлэгт ТУЗ байгуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ. ТУЗ-ийн гишүүнийг сонгохдоо Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан ерөнхий шаардлагаас гадна манлайллын ур чадвар, ажлын туршлага, эмнэлгийн хөгжилд хувь нэмэр оруулах хүсэл эрмэлзэл зэргийг харгалзана.</p> <p><u>ТУЗ-ийн гишүүдийн чадавхийг бэхжүүлэх, сургах:</u></p> <p>Бие даан ажиллах эмнэлэгт ТУЗ байгуулж зөвлөлийн гишүүдэд чадавх бэхжүүлэх сургалт зохион байгуулна.</p> <p><u>ТУЗ-ийн үйл ажиллагааны зардал, урамшуулал:</u></p> <p>ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь орон тооны ажилтан байна. Нарийн бичгийн дарга ажиллуулах, үйл ажиллагаа явуулах гэх мэт зардалтай байна.</p> <p>ТУЗ-ийн гишүүдэд зохих хэмжээний урамшуулал олгоно.</p>	

	<p>(Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль нь ТУЗ болон эмнэлгийн удирдлагын үйл ажиллагааг тодорхой зааглаж өгсөн. ТУЗ нь гүйцэтгэх удирдлагын өдөр тутмын үйл ажиллагаанд оролцохыг хориглосон).</p>	<p>гишүүд ажиллах сонирхолгүй байх; - ТУЗ-ийн гишүүд бие биенээ харилцан ойлгож нэг баг болон ажиллахад тодорхой цаг хугацаа шаардагдах; - ТУЗ-ын гишүүдийг сонгохдоо тэдний хууль эрх зүй, санхүү, удирдлагын чиглэлээр мэргэшсэн байдлыг үл харгалзах.</p>	
	<p>1.1.3. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын хяналтын механизм Бие даасан эмнэлгийн чанарын хяналт, баталгаажуулалтын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаанд төрийн бодлого, зохицуулалт зайлшгүй шаардлагатай байдаг. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах үндэсний түвшний нэгдсэн тогтолцоо нь бие даасан хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байгаа эмнэлэгт чанарын чиглэлээр мэргэжлийн тусалцаа, дэмжлэг үзүүлэхэд ихээхэн ач холбогдолтой байх болно. Тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах нь эмнэлгийн цаашдын хөгжил, өдөр тутмын үйл ажиллагааны чухал хэсэг байна. Эмнэлгийн чанарын асуудал хариуцсан ажилтнууд идэвх зүтгэл, санал, санаачлагатай ажиллах шаардлагатай. Чанарын менежерүүд харилцан туршлага солилцох, хамтран ажиллах механизм бүрдсэн байна.</p>	<p>Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын асуудлыг ЭМЯ-ны эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын хэлтэс, ЭМХТ-ийн магадлан итгэмжлэл, чанарын алба, ЭМДЕГ-ын Тусламж, үйлчилгээний чанарын газар зэрэг байгууллаг, газар хариуцан ажилладаг. Эмнэлгүүд чанарын асуудал хариуцсан багтай, "чанар" сайжруулах төлөвлөгөөг жил бүр батлан ажилладаг ч тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах асуудал салбарын тулгамдсан асуудал хэвээр байна. Эмнэлгийн үйл ажиллагааны гүйцэтгэлд суурилсан мэдээ, мэдээлэл хангалтгүй, статистик мэдээ, мэдээллийг бодлого боловсруулах, шийдвэр гаргах, хэрэгжилтийг зохицуулах, хяналт тавих үйл ажиллагаанд ашиглах чадавх хангалтгүй байна.</p>	<p><u>Тусламж, үйлчилгээний чанар сайжруулахад дэмжлэг үзүүлэх:</u> Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар сайжруулах үйл явцад арга зүйн дэмжлэг үзүүлэх тогтолцоо, бүтцийг илүү боловсронгуй болгоно. Энэ нь чанарын удирдлага, чадавх хангалтгүй байгаа жижиг эмнэлэгт ч чухал ач холбогдолтой байх болно. ЭМДЕГ-аас тусламж, үйлчилгээ худалдан авах нэхэмжлэлийг шалгахдаа Эмнэл зүйн удирдамж зааврыг мөрдсөн эсэхийг хянадаг. Цаашид эмнэлгүүд харилцан туршлагаа солилцох, "мэргэжил нэгтний үнэлгээ"-г салбарын түвшинд нэвтрүүлэн ажиллах, дэмжих механизм бүрдүүлнэ. <u>Чадавх бэхжүүлэх:</u> Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын удирдлагын сургалтыг эмнэлгийн чанарын менежер, эмнэлгийн мэргэжилтнүүдэд тогтмол зохион байгуулна. "Мэргэжил нэгтний үнэлгээ"-г бүрэн нэвтрүүлж эмч, эмнэлгийн мэргэжилтэнд сургалт зохион байгуулна.</p>

<p>1.2 Эмнэлэгт санхүү, хүний нөөцийн удирдлагын эрх мэдлийг цогц байдлаар шилжүүлэх</p>	<p>1.2.1 Эмнэлгийн эрх мэдэл Засгийн газраас эмнэлэгт бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны цар хүрээ, стратегийн төлөвлөлт, хүний нөөц, санхүү, үйл ажиллагааны удирдлагын талаарх шийдвэрийг бие даан гаргах эрх мэдлийг өгсөн байна. Засгийн газар болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь эмнэлгийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс үл оролцоно. Зөвхөн зохицуулалтын механизмгаар дамжуулан эмнэлгийн бие даасан байдлыг хөгжүүлнэ.</p>	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т бие даасан эмнэлгийн тусламж, үйлчилгээний удирдлага, зохион байгуулалт, санхүү, хяналт, эмнэлгийн үйлчилгээнд тавих шаардлага, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулиар зохицуулахаар хуульчилсан. Эрүүл мэндийн тухай болон Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулиар бие даасан эмнэлгийн гүйцэтгэх удирдлага, ТУЗ нь эмнэлгийн бүтэц, зохион байгуулалтаа тодорхойлох, байгууллагын хөгжлийн стратеги төлөвлөлтөө хийх, үйл ажиллагаагаа удирдан зохион байгуулах бүрэн эрхтэй байхаар хуульчлагдсан. Эмнэлэг байгууллагын хөгжлийн төлөвлөгөө батлан хэрэгжүүлж байна. Эмнэлгийг хэрхэн үр дүнтэй, үр ашигтай ажиллуулах талаарх мэдлэг, үр чадвараа байгууллагын удирдлагын баг дээшлүүлэх шаардлагатай.</p>	<p><u>Эрх мэдлийг эмнэлэгт шилжүүлэх:</u> Хүний нөөцийн болон санхүүгийн эрх мэдлийг эмнэлэгт цогц байдлаар шилжүүлнэ. Засгийн газар, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь эмнэлгийн үйл ажиллагаанд шууд оролцохгүй. Эмнэлгийн гүйцэтгэх удирдлагад олгосон эрх мэдэл эмнэлгийн тусламж, үйлчилгээний үр дүн, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэгдэнэ. <u>Эмнэлгийн хариуцлагыг нэмэгдүүлэх:</u> Эмнэлэгт эрх мэдлийг шилжүүлэхийн зэрэгцээ эмнэлгийн гүйцэтгэх удирдлага нь тусламж, үйлчилгээний чанар сайжруулах арга хэмжээг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох байгууллагын зүгээс мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллана. <u>Эмнэлгийн чадавх:</u> Бие даасан эмнэлгийн ТУЗ болон удирдлагын баг дараах чадварыг эзэмшсэн байна. -Бодлогын хэрэгжилт, зохицуулалт болон төсвийн хязгаарт нийцүүлэн эмнэлгийн бүтэц, зохион байгуулалтыг баталж, хүний нөөцийг төлөвлөх; - Эрүүл мэндийн салбарын бодлого, хүн амын эрүүл мэндийн хэрэгцээнд нийцсэн “Эмнэлгийн хөгжлийн хөтөлбөр” хэрэгжүүлэх;</p>
---	---	--	--

	<p>1.2.2. Эмнэлгийн эрх зүйн байдал</p> <p>Эмнэлгийн бие даасан байдлыг хэрэгжүүлж байгаа эмнэлэг нь төрийн болон орон нутгийн өмчит эмнэлэг байх учраас эмнэлгийн үл хөдлөх хөрөнгийг бусдад зарах, бусдаас худалдан авах асуудал Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар зохицуулагдана.</p> <p>Эмнэлэг нь өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр эрх зүйн статусаа өөрчлөх эрхгүй байна.</p>	<p>Эмнэлгийн өмчлөлийн асуудлыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар зохицуулж байна.</p> <p>Эмнэлгийн барилгын талаар санхүүгийн тайланд тусгагддаг ч, эмнэлгийн газрын асуудал тодорхойгүй байдаг. Иймд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын заавраар (А-1/3550, 2017) эмнэлгийн газрын үнэлгээг санхүүгийн тайланд тусгах үйл ажиллагаа хийгдэж байна.</p> <p>Эрүүл мэндийн тухай хуулийн 17.2-т зааснаар төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг байгуулах, өөрчлөн зохион байгуулах, татан буулгах шийдвэрийг зөвхөн Засгийн газар гаргана.</p>	<p>- Эмнэлэг удирдан зохион байгуулах, хүний нөөц, санхүү, гүйцэтгэлийн удирдлагын чиглэлээр суралцсан, зохих мэдлэг, чадвартай байх.</p> <p><u>Эмнэлгийн санхүүгийн тайланд эмнэлгийн газрын асуудлыг тусгах.</u></p> <p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зааврын дагуу эмнэлгийн газрын үнэлгээг эцэслэн, газрыг эмнэлгийн санхүүгийн тайланд тусгадаг болох.</p> <p><u>Хуулийн зохицуулалт:</u></p> <p>Засгийн газар, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь бие даасан эмнэлгийг өөрчлөн зохион байгуулах, татан буулгах шийдвэр гаргах нөхцөл, үйл явцыг цаашид хуульд нарийвчлан тусгах.</p>
--	--	---	--

<p>1.3 Эмнэлгийн үйл ажиллагаанд тавих мэргэжлийн хяналт, зохицуулалт</p>	<p>Хяналт, шалгалтын уялдаа холбоо Эмнэлгийн үйл ажиллагааг хөндлөнгөөс хянан мэргэжил арга зүйн удирдлагаар хангах байгууллагуудын /УМХЕГ, Тусгай зөвшөөрөл олгох болон магадлан итгэмжлэх байгууллага/ уялдаа холбоо сайн, тэдгээр нь хоорондоо болон ЭМЯ-тай мэдээллээ цаг тухайд нь харилцан шуурхай солилцдог байна.</p>	<p>Эмнэлгийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дэмжлэгт хяналт хийх, зохицуулах байгууллагуудын хяналт шалгалтын уялдаа холбоо хангалтгүй байгаагаас нэг эмнэлэгт давхардсан байдлаар хэт олон хяналт, үнэлгээ, шалгалт хийх явдал элбэг байна.</p>	<p><u>Хяналт, зохицуулалт, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх байгууллагуудын уялдаа холбоо сайжруулах.</u></p>
<p>Гүйцэтгэл хангалтгүй байгаа эмнэлэгт хяналт- шинжилгээ, үнэлгээ, хөндлөнгийн хяналт, шалгалтыг цаг тухайд нь хийж, шаардлагатай тохиолдолд холбогдох байгууллага (ЭМЯ)- д мэдэгдэн хариу арга хэмжээ авна.</p>	<p>Улсын эмнэлгүүд үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авч магадлан итгэмжлэлд хамрагдаж байгаа ч эдгээр нь чанар, үр ашигт нөлөөлөх нөлөөлөл болж чадахгүй байна.</p>	<p>Мэргэжлийн хяналт нь захиргааны шинжтэй, торгох, шийтгэх хандлагаас дэмжлэгт хяналтын хэлбэрт шилжсэн хэдий ч хэрэгжиж байгаа дүрэм, журмыг тухай бүрт бүрэн шуурхай солилцдоггүйгээс зарим тохиолдолд эрүүл мэндийн байгууллагыг төөрөгдөлд оруулах тохиолдол гарч байна.</p>	<p><u>Бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт.</u> Хянаж үнэлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хэрэгжилтийг зохицуулагч байгууллагуудын үүрэг, үйл ажиллагааны давхардлыг арилгах чиглэлээр хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгоно.</p>
<p>Хяналт шалгалтын арга барил Эмнэлгийн хяналт нь тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал болон түүнд нөлөөлөх эрсдлийг илрүүлэх, засч залруулахад чиглэсэн байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, хөндлөнгийн хянаот шалгалтаас гарсан зөвлөмж нь эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулахад чиглэсэн байх бөгөөд эмнэлгүүд зайлшгүй хэрэгжүүлдэг байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, хяналт шалгалтад мэргэжлийн хяналтын байцаагчаас гадна тухайн чиглэлийн мэргэжлийн нийгэмлэг, холбоо, үйлчлүүлэгчийн төлөөллийн оролцоог хангасан байна.</p>	<p>Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд эмнэлгийн байгууллагад мэргэжлийн хяналт хийх чадавх бүхий институт бий болгох боломжийг судална.</p>	<p><u>Хяналт, шалгалтын арга барилыг шинэчлэх</u> Байгууллагын өөрийн үнэлгээг нэвтрүүлж хяналт шалгалтын үр дүн, нөлөөг дээшлүүлнэ. Торгох, шийтгэх арга барилаас эмнэлэгт дэмжлэг</p>	<p><u>Хяналт, зохицуулалт, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх байгууллагуудын уялдаа холбоо сайжруулах.</u></p>

Мэдээнд дүн шинжилгээ хийх үйл ажиллагаа

Эмнэлгийн үйл ажиллагаанд хамтран оролцогч байгууллагууд нь ь эмнэлгийн үйл ажиллагааны холбогдох мэдээ, мэдээлэлд хяналтын өмнө болон хяналтын үеэр дүн шинжилгээ хийн тулгамдаж буй асуудлыг илрүүлэх, цаашид хэрхэн сайжруулах, сэргийлэх талаар нарийн заавар зөвлөгөө өгөх чадвартай байна. Хяналтын үр дүнг холбогдох байгууллага, үйлчлүүлэгчдэд ил тод, нээлттэй мэдээлнэ.

үзүүлэх хэлбэр рүү шилжинэ. Эмнэлгийн мэргэжилтэн, мэргэжлийн нийгэмлэг холбоо, төрийн бус байгууллагуудыг хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, шалгах үйл ажиллагаанд өргөнөөр татан оролцуулж зөвлөмж дэмжлэг үзүүлэх механизмыг бий болгоно. Үүнтэй холбоотойгоор хяналт шалгалтад ашиглаж буй арга хэрэгслийг шинэчилж сайжруулна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, шалгалтын мөрөөр авах арга хэмжээ нь “зорилтот арга хэмжээ”, “тусгай арга хэмжээ” гэх мэт тодорхой үе шат, төрөлтэй байна.

Мэргэжлийн хяналтыг үр дүнтэй явуулахад хангалттай санхүүжилт шаардлагатай. “Ижил мэргэжилтний үнэлгээ” сайн дурын үндсэн дээр хийгдэж болно.

Мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх:

Эмнэлгийн гүйцэтгэлийг оновчтой илэрхийлэх цөөн тооны мэдээ, мэдээллийг тогтмол хугацаанд авч дүн шинжилгээ хийдэг байна.

Мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлыг сайжруулахдаа шалгуур үзүүлэлтийн тодорхойлолт, мэдээ, мэдээлэл цуглуулах үйл явцыг стандартчилж, энэ чиглэлээр хүний нөөцийн чадавх бэхжүүлэх сургалт зохион байгуулна.

Хяналт үнэлгээнээс гарсан зөвлөмж түүний мөрөөр авсан арга хэмжээг холбогдох байгууллагад мэдээлэхээс гадна эмнэлгийн цахим хуудсаар ард иргэдэд ил, тод, нээлттэй мэдээлнэ.

<p>1.4. Гэрээ, зах зээлийн механизм</p>	<p>1.4.1. Олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулахад иргэдийн оролцоог нэмэгдүүлсэн байна. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний алдааг илрүүлэх, гомдол барагдуулах талаарх эрх зүйн орчин боловсронгуй болсон байна.</p>	<p>Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарт иргэдээс тавих хяналт сул, үйлчлүүлэгчид эмнэлгийн тусламж, үйлчилгээний талаар гомдлоо хэнд, хэрхэн уламжилж шийдүүлэх талаарх мэдээлэл, мэдлэг хомс байна.</p>	<p><u>Үйлчлүүлэгчийн эрхийг хамгаалах:</u> Эмнэлгийн үйл ажиллагаа болон эмнэлгийн ажилтантай холбоотой гомдлоо хэрхэн шийдвэрлүүлэх арга зам нь тодорхой байхаас гадна өвчтөний өөрийн нь хүлээх үүрэг, хариуцлагыг эмнэлэг өөрийн байгууллагын дүрэм, журамдаа тодорхой тусгасан байна. Эмнэлгийн (эмнэлгийн мэргэжилтний) хариуцлагын даатгалын тогтолцоог бий болгож, эмнэлэг нь эмч нараа (үндэсний болон олон улсын) хариуцлагын даатгалд хамруулах боломжийг судална. Мэргэжлийн зөвлөл/холбоодын хүлээх үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх нь чухал.</p>
<p>1.4.2. Гэрээлэх, эмнэлгийн сүлжээ Бие даасан эмнэлэг бусад эмнэлгүүдтэй холбогдон “Эмнэлгийн сүлжээ (кластер)” хэлбэрээр гэрээний үндсэн дээр үйлчилгээ үзүүлж, хоорондоо өвчтөн шилжүүлж болно. Эмнэлгүүд “холбоо” байгуулан эрх ашгаа хамгаалах, харилцан туршлага солилцох боломжтой. Эмнэлгүүд эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээлж санхүүжилтийг үр ашигтай, үр дүнтэй ашиглах талаар өрсөлдөнө.</p>	<p>1.4.2. Гэрээлэх, эмнэлгийн сүлжээ Бие даасан эмнэлэг бусад эмнэлгүүдтэй холбогдон “Эмнэлгийн сүлжээ (кластер)” хэлбэрээр гэрээний үндсэн дээр үйлчилгээ үзүүлж, хоорондоо өвчтөн шилжүүлж болно. Эмнэлгүүд “холбоо” байгуулан эрх ашгаа хамгаалах, харилцан туршлага солилцох боломжтой. Эмнэлгүүд эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээлж санхүүжилтийг үр ашигтай, үр дүнтэй ашиглах талаар өрсөлдөнө.</p>	<p>Эмнэлэг үйлчлүүлэгчээ татах өрсөлдөөн бага. Төлбөрийн арга нь өрсөлдөөнийг дэмжиж чадахгүй байна. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээрх үйл ажиллагаа, ядуу эмзэг бүлгийн иргэдэд үзүүлэх тусламж, үйлчилгээний санхүүжилт тодорхой бус, хангалтгүй байна. Эмнэлгүүд гэрээний үндсэн дээр хамтран ажиллах туршлага хомс.</p>	<p><u>Гэрээ байгуулах:</u> Эмнэлгүүд тусламж, үйлчилгээ үзүүлсэн санхүүжилт авах гэрээг ЭМДЕГ-тай байгуулна. “Эмнэлгийн сүлжээ”-гээр дамжуулан иргэдэд үзүүлэх тусламж, үйлчилгээг өргөжүүлнэ. <u>Мэдээллийн ил тод байдал:</u> Засгийн газар, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь эмнэлгийн гүйцэтгэл, тусламж, үйлчилгээний төлбөрийн талаарх мэдээллийг ил, тод мэдээлнэ.</p>
<p>1.5 Эмнэлгийн бие даасан</p>	<p>1.5.1. Хяналт- шинжилгээ үнэлгээ Засгийн газар нь эмнэлгийн бие</p>	<p>Аливаа шинэчлэлийн үр дүнд үнэлгээ өгч, хариу арга хэмжээ шуурхай авах үйл явц</p>	<p><u>Хяналт-шинжилгээ:</u> Шинэчлэлийн үйл явцад байнга явцын</p>

<p>байдлыг хангах шинэчлэлийн явцыг үнэлэх</p>	<p>даасан байдлыг бэхжүүлэхтэй холбоотой хууль, дүрэм, журмын хэрэгжилттэд тогтмол хяналт тавьж, хэрэгжилт хангалтгүй байгаа шалтгааныг тодруулах, засч залруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Шаардлагатай тохиолдолд хууль эрх зүйн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулна. Засгийн газар эмнэлгийн бие даасан байдлыг хангах шинэчлэлийн үр дүнг 2 жил тутам үнэлэн, тухайн эмнэлгийн зохицуулалт, санхүүжилтийн аргыг боловсронгуй болгох арга хэмжээг хэрэгжүүлнэ.</p>	<p>дутагдалтай байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээнээс гарсан үр дүн, зөвлөмжийн хэрэгжилтэд эргэн хяналт хийх тогтолцоо хангалтгүй.</p>	<p>хяналт-шинжилгээ хийж, үр дүнг Эмнэлгийн бие даасан байдлыг зохицуулах зөвлөлөөр хэлэлцүүлэн шаардлагатай арга хэмжээг тухай бүрт авна. <u>Үнэлгээ:</u> Шалгуур үзүүлэлтийн дагуу эмнэлгийн гүйцэтгэлийг үе шаттай үнэлж, тухайн бие даасан эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, тэгш байдлыг хангах, иргэдийг санхүүгийн эрсдэлд орохоос хэрхэн сэргийлж байгаа талаар танилцаж, шаардагдах арга хэмжээг шуурхай авдаг тогтолцоо бүрдүүлнэ.</p>
<p>2.1 Эмнэлгийн санхүүжилтийн эх үүсвэр</p>	<p>2.1.1 Санхүүжилтийн эх үүсвэр Эмнэлэг нь -Улсын төсөв, -Эрүүл мэндийн даатгал, -Аж ахуйн нэгж, байгууллага, хамт олон, иргэний хандив, -Эмнэлгийн төлбөртэй тусламж, үйлчилгээ - Хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс тус тус санхүүжих боломжтой. Эмнэлгүүд бие даан ажиллахад улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт гол үүрэг гүйцэтгэнэ. Эрүүл мэндийн салбарын төсөв</p>	<p>Үндсэн чиглэл 2: Санхүүжилт Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийн эх үүсвэр нь улсын төсөв, эрүүл мэндийн даатгал, Засгийн газрын тусгай сан, байгууллага, хамт олон, иргэдийн хандив, төлбөртэй тусламж, үйлчилгээ болон бусад үйл ажиллагааны орлого байна хэмээн заасан. Эмнэлгийн орлогын эх үүсвэр эмнэлэг бүрт харилцан адилгүй, дунджаар эмнэлгийн орлогын 50-аас дээш хувийг улсын төсөв, 30 гаруй хувийг эрүүл мэндийн даатгал, 5 хүртэлх хувийг төлбөртэй тусламж, үйлчилгээний орлого эзэлж байна. (Joint Learning Network. 2017).</p>	<p><u>Ухуулан таниулах ажил:</u> Бие даасан эмнэлэгт улсын төсвийн санхүүжилтийг бууруулснаас үүсэх сөрөг үр дагавар, эрүүл мэндийн зах зээлийн онцлогийн талаар СЯ болон бусад холбогдох байгууллагад ухуулан таниулах ажлыг зохион байгуулна. <u>Стратегийн худалдан авалт:</u> Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын хүрээнд улсын төсвийн санхүүжилтийг ЭМДЕГ-т нэгтгэн эмнэлгийн тусламж, үйлчилгээг гүйцэтгэлд суурилан санхүүжүүлэх арга хэмжээг авна. <u>Улсын төсвийн болон даатгалын санхүүжилтийг нэмэгдүүлэх:</u> Төрөөс эрүүл мэндийн талаар</p>

<p>нэмэгдэхийн хирээр эмнэлгийн улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг тусламж, үйлчилгээний тоо, төрөл, гүйцэтгэлд үндэслэн нэмэх боломжтой.</p>		<p>баримтлах бодлогын хүрээнд эрүүл мэндийн зардлын ДНБ-д эзлэх хувийг ДЭМБ-ын зөвлөмжид (5%) хүргэх, засгийн газрын нийт зардалд эрүүл мэндийн салбарын зардлыг 12 хувьд хүргэх арга хэмжээ авна.</p>
<p>2.1.2 Төлбөртэй тусламж, үйлчилгээний орлого:</p> <p>Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогод Эрүүл мэндийн салбарын зардалд иргэний шууд төлөх төлбөрийн эзлэх хэмжээг 25 хувь хүртэл бууруулах зорилт туссан. Иймд бие даасан эмнэлгийн төлбөртэй тусламж, үйлчилгээнээс олох орлогын дээд хэмжээнд хязгаар тавина.</p> <p>Эмнэлгүүд төлбөртэй тусламж, үйлчилгээнээс олсон орлогоо тусламж, үйлчилгээний чанар сайжруулах, ажлын гүйцэтгэлийг нэмэгдүүлэхэд ихэвчлэн зарцуулна.</p> <p>Албан бус төлбөр аажимдаа буурна.</p>	<p>Эмнэлгийн төлбөртэй тусламж (албан), үйлчилгээнээс олох орлого дунджаар эмнэлгийн төсвийн 5 хувийг эзэлж байна.</p> <p>Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4-т заасан төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний жагсаалт, төлбөрийн хэмжээг ЭМЯ, СЯ хамтран баталж улсын хэмжээнд мөрддөг.</p> <p>(Одоогоор Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2017 оны 264/А/293 дугаар тушаал хэрэгжиж байна).</p> <p>Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5-д "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага хууль тогтоомжид нийцүүлэн нэмэлт болон төлбөртэй тусламж, үйлчилгээ үзүүлж, олсон орлогыг эрүүл мэндийн ажилтны хөдөлмөрлөх нөхцөлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах, засвар, үйлчилгээ хийхэд зарцуулах бөгөөд уг орлогыг зарцуулах үлгэрчилсэн журмыг санхүүгийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална" гэж заасан.</p> <p>Эрүүл мэндийн Үндэсний тооцоогоор Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахдаа хувь хүний хармаанаасаа төлсөн төлбөрийн</p>	<p><u>Журмын тогтмол шинэчлэл:</u></p> <p>Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд иргэний шууд төлөх төлбөрийн хэмжээг зохицуулсан өнөөгийн дүрэм, журам нь төлбөртэй тусламж, үйлчилгээг хязгаарлах боломжийг бүрдүүлж байгаа давуу талтай. Энэхүү журмыг цаашид ашиглах ба явцын үнэлгээ, эмнэлгийн санал, хүсэлтэд үндэслэн тогтмол шинэчлэн хэрэгжүүлнэ.</p> <p>Төлбөртэй тусламж, үйлчилгээний тарифыг ядуу, эмзэг бүлгийн иргэдэд хөнгөлөх, улсын төсвийн татаасыг эмнэлэгт өгөхөөс гадна эмнэлгийн нийт оронд эзлэх төлбөртэй орны хувьд зохицуулалт хийнэ.</p> <p>Эмнэлгийн төлбөртэй тусламж, үйлчилгээний орлогыг зарцуулах үлгэрчилсэн журмыг Төсвийн хуультай нийцүүлэн боловсруулж, хэрэгжүүлнэ.</p> <p><u>Зохицуулалт ба эмнэлгийн чадавч:</u></p> <p>Эмнэлгийн албан бус төлбөрийг илрүүлэх, бууруулах арга зам, зохицуулалтын механизмыг холбогдох талууд төдийгүй эмнэлгүүд өөрсдөө байгууллагынхаа түвшинд хэлэлцэн шийдвэрлэх арга замыг олж, хэрэгжүүлнэ.</p> <p>Албан бус төлбөрийн хэмжээг</p>

	<p>2.1.3 Нэмэлт үйлчилгээний орлого</p> <p>Бие даасан эмнэлэг тусламж, үйлчилгээнд саад учруулахгүйгээр нэмэлт орлого олох асуудал нь нээлттэй байна. Тухайлбал: ашиглахгүй байгаа зай талбайг түрээслэх, эмнэлгийн хоол, угаалгын үйлчилгээг гэрээ, түрээсээр ажиллуулах, хандив, тусламж гэх мэт.</p> <p>Эмнэлгийн бусад үйл ажиллагааны орлогоос олох нэмэлт орлого ил тод нээлттэй болсон байна</p> <p>ТУЗ-өөс холбогдох хууль тогтоомж, журамд нийцүүлэн түрээслэх үйл ажиллагаа, түрээслэгч, түрээсийн хэмжээг хэлэлцэн баталснаар Эмнэлгийн удирдлага түрээслэгчтэй гэрээ хийж, олсон орлогоо захиран зарцуулдаг байна.</p>	<p>хэмжээ 2014 оны байдлаар 35,4 хувь байна.</p> <p>Эмнэлгүүд төлбөртэй ерөө ажиллуулах, талбай түрээслүүлэх, цайны газар ажиллуулах, олон улсын байгууллагаас хандив, тусламж авах зэргээр нэмэлт орлого олж байна. Энэхүү нэмэлт орлогыг жилийн төсөвт тусгаж, Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2-т заасны дагуу Төрийн сангийн нэгдсэн дансанд саадгүй байршуулах үүрэгтэй.</p> <p>Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4-т бүхий л нэмэлт орлого тухайлбал, төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, түүгээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байна гэж заасан.</p> <p>Нэмэлт орлого нэмэгдэх тусам улсын төсвийн санхүүжилт буурах хандлага байсаар байна. Нэмэлт орлогыг эмнэлгийн хөгжил болон ажилтны нийгмийн баталгааг хангахад зарцуулах боломж бага учраас эмнэлгүүдэд нэмэлт орлого олох сонирхол, хөшүүрэг бага байна.</p> <p>– Төрийн өмч, хөрөнгийг түрээслүүлэх үйл ажиллагааг Засгийн газрын 2016 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан журмаар Төрийн өмчийн бсдлого, зохицуулалтын газар улсын хэмжээнд зохицуулж байна.</p>	<p>бууруулахад эмч болон өвчтөний албан бус төлбөрийн талаарх зан, үйлийг өөрчлөх, эмнэлгийн ажилтны цалин урамшууллыг нэмэгдүүлэх, эмнэлэгт албан бус төлбөрийн эсрэг хариуцлагын механизмыг цогцоор нь хэрэгжүүлэх шаардлагатай.</p> <p><u>Засгийн газрын тогтоолд өөрчлөлт оруулах:</u></p> <p>– Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэгтэй уялдуулан Засгийн газрын “Төрийн өмч, хөрөнгийг түрээслүүлэх тухай” 2016 оны 134 дүгээр тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулж, бие даасан эмнэлгийн түрээсийн орлогыг төвлөрсөн төсөвт татахгүйгээр эмнэлэг өөрөө захиран зарцуулах, түрээслэгчийг эмнэлэг өөрөө сонгож, гэрээ байгуулах боломжийг бүрдүүлэх талаар СЯ-тай хэлэлцэнэ.</p>
--	--	--	--

		<p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Түрээсийн төлбөрийг улсын төвлөрсөн төсөвт оруулна. - Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын 2016 оны 109 дүгээр тушаалаар худалдаа үйлчилгээний зориулалтаар түрээслэх түрээсийн жишиг үнийг тогтоосон. (1м.кв-15000₮ гэх мэт). - Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2017 оны 53 дугаар тушаалаар 60 м.кв-аас дээш талбай бол түрээслэгч байгууллагыг сонгохоор журамлагдсан. - Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлд туслах үйл ажиллагаа эрхлэх, орлогыг зарцуулах зохицуулалтыг хийж өгсөн. 	
<p>2.2 Эмнэлгийн тусламжийн төлбөрийн арга</p>	<p>2.2.1 Төлбөрийн арга</p> <p>Эмнэлгийг улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалаас Оношийн хамааралтай бүлгээр санхүүжүүлнэ. ЭМДЕГ тусламж, үйлчилгээний суурь тариф, Оношийн хамааралтай бүлгийн өртгийн жин, нөлөөлөх хүчин зүйлсийг эмнэлгийн оролцоотой судалж жил бүр шинэчлэн тогтооно. ЭМДЕГ нь гүйцэтгэлийн урамшууллыг харилцан тохиролцсон гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн биелэлт, нотолгоонд суурилсан эмнэлзүйн үйл ажиллагаа, даатгуулагчдын сэтгэл ханамж зэрэгт үндэслэн нэмж олгож болно.</p>	<p>Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6, болон 9 зүгээр зүйлийн 9.1-д Төр хариуцах болон эрүүл мэндийн даатгалын сангаас төлбөрийг нь хариуцах тусламж, үйлчилгээг Тохиролдолд суурилсан төлбөрийн аргаар санхүүжүүлэхээр заасан. Эмнэлэгт Эрүүл мэндийн даатгалын сангаас Оношийн хамааралтай бүлгээр (ОХБ)-ээр санхүүжилт олгож байна. Харин төр хариуцах тусламж, үйлчилгээний ОХБ-ийг тодорхойлж СЯ-тай хамтарсан тушаалаар баталгаажуулсан. 2020 оноос эмнэлгийн бие даасан байдлыг хэрэгжүүлж байгаа эмнэлгүүдэд үе шаттай хэрэгжүүлж байна.</p>	<p><u>Шинээр боловсруулсан ОХБ-ийг нэвтрүүлэх:</u></p> <p>ЭМЯ-наас эмнэлгүүдэд олгох улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг шинэчлэн боловсруулсан.</p> <p>ОХБ, өртгийн жинг ашиглан нийт төсвийн аргаар санхүүжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж, түүний үр дүнд үндэслэн ангилал, өртгийн жинг боловсронгуй болгох, улмаар бусад эмнэлэгт үе шаттайгаар нэвтрүүлж, тогтмол шинэчилнэ.</p> <p><u>ЭМЯ/ЭМДЕГ-ын чадавх:</u></p> <p>Эмнэлгийн тусламж, үйлчилгээний төлбөрийн аргын үр нөлөө, тарифыг жил бүр үнэлж, шинэчлэн, эмнэлэгтэй</p>

			<p>харилцан зөвшилцөж, стратегийн худалдан авалт хийх чадавхийг үндэсний хэмжээнд бүрдүүлнэ.</p> <p><u>Эмнэлгийн чадавх:</u></p> <p>Эмнэлэг санхүүгийн удирдлагын чадавхаа байнга дээшлүүлэх, удирдлагын багаа сургах, эмнэлгийн хэмжээнд санхүүгийн бодлого, төлөвлөлт, заавар журам боловсруулан мөрдөнө.</p> <p>Эмнэлэг нь ЭМДЕГ-тай төлбөрийн арга, тариф, нөлөөлөх хүчин зүйлийг хэлэлцэн тохиролцох, гэрээ байгуулах ур чадвараа байнга сайжруулна.</p>
<p>2.3 Эмнэлгийн төсвийн төлөвлөлт, зарцуулалт</p>	<p>2.3.1 Төсвийн төлөвлөлт</p> <p>Төсвийн төсөл боловсруулах, батлах үйл явц Төсвийн тухай хуулийн дагуу явагдана.</p> <p>Бие даасан эмнэлгээс боловсруулж, ТУЗ-өөрөө хэлэлцүүлсэн төсвийн төслийг үндэслэн ЭМЯ салбарын төсвийн төсөлд тусган СЯ-д хүргүүлнэ. Сангийн яамнаас шилжилтийн үед эмнэлгийн нийт төсвийн хязгаарыг эмнэлгийн үзүүлэх тусламж, үйлчилгээний тоо, төрөл, үйл ажиллагааны төлөвлөгөөнд үндэслэн тогтооно.</p> <p>Урт хугацаандаа эмнэлгүүд төсвөө өөрсдөө боловсруулан худалдан авагч (санхүүжүүлэгч) байгууллагуудтай гэрээ хийнэ.</p>	<p>Эмнэлгийн үзүүлэх тусламж, үйлчилгээний тоо, төрөлд үндэслэн Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийн төлөвлөлт хийгдсэн.</p> <p>Одоогоор Эмнэлгийн засаглал хэрэгжүүлж эхэлсэн 3 эмнэлэгт эдийн засгийн ангиллаар бус тусламж, үйлчилгээний тоо хэмжээ, үйл ажиллагаанд үндэслэн төсвөө боловсруулах боломжийг бүрдүүлэх талаар Сангийн яамтай зөвшилцөлд хүрсэн.</p>	<p><u>Журам боловсруулах:</u></p> <p>Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан эмнэлэгт санхүүжилт олгох журам, гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг Сангийн яамтай хамтран боловсруулж, хэрэгжүүлнэ. Хэрэгжилтийн үнэлгээнд үндэслэн тогтмол шинэчлэн боловсронгуй болгоно. “ОХБ-т суурилсан нийт төсвийн аргаар” санхүүжүүлэх болно.</p>

	<p>2.3.2 Төсвийн зарцуулалт</p> <p>Эмнэлгүүд бодит хэрэгцээндээ тохируулан төсвийг зарцуулах, хэмнэх боломжийг олгох зорилгоор төрийн сангаас тухайн эмнэлгийн төсвийг сараар биш улирлаар /улирлын эхэнд/ эсвэл хагас жилээр олгож, эмнэлгүүд бодит хэрэгцээндээ тохируулан төсвөө зарцуулах, хэмнэх боломжийг олгоно.</p>	<p>Төсвийн тухай хуульд заасны дагуу эмнэлэг бүх санхүүжилтээ төрийн сангаар дамжуулан авч, зарцуулж байна. Эмнэлэг улсын төсөв, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих төсөвт зохицуулалт хийх саналаа ЭМЯ-нд, ЭМЯ нь СЯ-нд хүргүүлдэг. Сангийн яам хянан зөвшөөрсний дагуу төсвийн сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулан шийдвэрлэдэг.</p> <p>Төсөвт зохицуулалт хийхдээ Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.7-д заасны дагуу хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно.</p> <p>Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар төсөвт зохицуулалт хийх боломж олгосон. Эмнэлгүүд төсвийн зохицуулалт хийх шаардлагатай бол саналаа Сангийн яаманд зааврын дагуу хүргүүлж, зөвшөөрөл авах ёстой. Гэвч энэхүү үйл явц нь цаг хугацаа их шаарддаг, санал батлагдахгүй байх магадлал өндөр тул эмнэлгүүд зохицуулалт хийх сонирхол багатай байна.</p> <p>Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд эмнэлгийн ТУЗ төсвийн хуваарийг батлахаар заасан ч одоогоор мөрдөж байгаа Төсвийн тухай хууль, Сангийн сайдын баталсан журамтай зөрчилдөж байна.</p>	<p><u>Хууль, журмын өөрчлөлт:</u></p> <p>Төрийн сангаас төсвийг улирлаар (хагас жилээр) бие даасан эмнэлэгт олгох боломжийг СЯ-тай хэлэлцэнэ.</p> <p><u>Хөндлөнгийн хяналт:</u></p> <p>Хөндлөнгийн санхүүгийн аудит хууль дүрмийн хэрэгжилтэд хяналт тавина.</p> <p>Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тусламж, үйлчилгээний талаар шинээр гарсан дүрэм журам, стандартын талаарх мэдээллээр хөндлөнгийн хяналтын байгууллагыг (мэргэжлийн хяналт, санхүүгийн аудит) хангана.</p>
	<p>2.3.3 Эмнэлгийн төсвийн төлөвлөлт</p>		<p><u>Эмнэлгийн дүрэм, журам:</u></p>

	<p>Эмнэлэг тусламж, үйлчилгээний тоо, төрөл, үйл ажиллагааны хүрээ, үйлчлүүлэгчийн эрэлт, хэрэгцээ, өвчлөлийн байдалд үндэслэн төсвийн төсөл боловсруулж, ТУЗ-өөр хэлэлцүүлэн холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлж, батлуулна. Харин батлагдсан төсвийн хуваарийг эмнэлгийн ТУЗ батална.</p>	<p>Эмнэлгүүд нь ЭМДҮЗ-ийн тогтоол, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалаар баталсан ОХБ-ын журмын дагуу эмнэлгийн хүчин чадалд үндэслэн төсвөө үзүүлэх тусламж, үйлчилгээний тоо хэмжээ, нэгжийн өртөгт үндэслэн төлөвлөж байна.</p>	<p>Эмнэлгийн төсвийн төлөвлөлтийн аргачлал, төсөв боловсруулах журмыг боловсруулж, хэрэгжүүлнэ.</p> <p>Эмнэлгийн удирдлагууд төсөв, төлөвлөлтийн талаар сургалтад бүрэн хамрагдан нэгдсэн ойлголттой байж төсвийн төлөвлөлтөд бүгд оролцоно.</p> <p><u>Эмнэлгийн чадавх:</u></p> <ul style="list-style-type: none"> – Төсвийн төслийг хянан хэлэлцэх мэдлэг, ур чадварыг эзэмшүүлэх сургалтыг ТУЗ-ийн гишүүдэд үе шаттай зохион байгуулна. – Эмнэлгийн удирдлага өөрийн эмнэлгийн тусламж, үйлчилгээний тоо, төрөл, зардлын дүн шинжилгээ, үйл ажиллагаанд үндэслэн төсвөө боловсруулна. – Эмнэлэг санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайландаа дүн шинжилгээ хийх, тайлангаас гарсан дүгнэлтийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг цаг алдалгүй авах чадавх бүрдүүлсэн байна.
<p>2.4 Эмнэлгийн төсвийн хэмнэлт ба алдагдал Санхүүгийн эрсдэл</p>	<p>2.4.1 Хэмнэсэн төсөв</p> <p>Эмнэлэг санхүүгийн жилд хэмнэсэн төсвөө дээд түвшний байгууллагаас зөвшөөрөл авалгүйгээр эмнэлгийн дүрэм, журмын дагуу зарцуулна. Зарцуулалтад эмнэлгийн ТУЗ хяналт тавина.</p> <p>Эмнэлэг тусламж, үйлчилгээний тоо хэмжээ, чанараа бууруулахгүйгээр төсвөө үр ашигтай зарцуулж,</p>	<p>Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9-д орсон нэмэлт өөрчлөлтөөр төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн төв болон нэгдсэн эмнэлэг төсвийн хэмнэлтээ Төрийн сангийн дансанд татан төвлөрүүлэхгүйгээр өөрөө ашиглах эрхийг нээж өгсөн. Гэвч энэхүү өөрчлөлтийн талаар эмнэлгүүд мэдээлэл багатай байна.</p> <p>Төсвийн тухай хуулийн 46 дугаар зүйлд зааснаар төсвийн хэмнэлт болон үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг ажилтны</p>	<p><u>Дүрэм, журмын өөрчлөлт:</u></p> <p>Төсвийн хэмнэлтийг зарцуулах журмыг ТУЗ-өөр батлаж, хэрэгжүүлэх</p> <p><u>Эмнэлгийн чадавх:</u></p> <p>Эмнэлгийн удирдлагын баг нь хүний, санхүүгийн болон эд материалын нөөцийг үр дүнтэй, үр ашигтай зарцуулах, хэмнэлт гаргах мэдлэг, ур чадвартай байна.</p> <p>Эмнэлэг түүний тасаг, нэгжүүд хүрэх</p>

<p>оновчтой удирдсан тохиолдолд эмнэлэгт төсвийн хэмнэлт үүсэх магадлалтай.</p>	<p>урамшуулал, нийгмийн баталгааг сайжруулах, байгууллагын хөрөнгө оруулалт зэрэгт зарцуулах боломжтой.</p> <p>Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.6.4-т эмнэлгийн захирал хэмнэсэн зардлаа тусламж, үйлчилгээний чанар, ажилтны нийгмийн баталгааг дээшлүүлэхэд зарцуулна гэсэн боловч хэмнэлтийг ашиглах “зөвшөөрөл” авах процесс төвөгтэй байсаар байна.</p> <p>2020 оноос 3 эмнэлэг (УНТЭ, АӨСТ, УГТЭ) Төрийн сан дээр бие даасан эмнэлэг гэдэг ангилал, дансанд мөнгө нь байршиж байгаа бөгөөд энэ нь эдийн засгийн ангилал байхгүй, хэмнэсэн үед төрийн санд татахгүй байхаар зохицуулагдсан.</p>	<p>түвшин бүхий санхүүгийн шалгуур үзүүлэлттэй байж санхүүгийн гүйцэтгэлийн үзүүлэлтийг эмнэлгийн удирдлага тогтмол хянанана. Шаардлагатай үед зохих арга хэмжээ авч хэвшинэ.</p> <p>Төсөв хэмнэх, үр ашгийг нэмэгдүүлэх нь тусламж, үйлчилгээний хүртээмж, чанарт сөрөг нөлөө үзүүлэхгүй байна.</p> <p><u>Сургалт, мэдээлэл:</u></p> <p>Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас шинээр гарсан хууль эрх зүйн зохицуулалтын талаар мэдээлэл, гарын авлага боловсруулж эмнэлэгт хүргүүлнэ.</p>
<p>2.4.2 Өр/алдагдал</p> <p>Эмнэлэг өрийн хуримтлал үүсгэн “өрөө төлж чадахгүй болсон” тохиолдолд өрийг өмчлөгч төлөх эрсдэл гарах магадлалтай.</p> <p>Иймд эмнэлгийн өрийн зохицуулалтад эмнэлэг өр үүсгэх зайлшгүй нөхцөл үүссэн үед, холбогдох шийдвэрийг өмчлөгч байгууллагаас зөвшөөрөл авч гаргах талаарх хууль эрх зүйн орчин бүрдсэн байна.,</p> <p>Гэхдээ, эмнэлэг “өр үүсгэхгүй байх” гэсэн үндэслэлээр иргэдэд үзүүлэх тусламж, үйлчилгээгээ тасалдуулах, зогсоох, чанаргүй тусламж, үйлчилгээ үзүүлэх эрсдэл гаргахгүй байхад өмчлөгч байгууллага анхаарч, сэргийлэх арга хэмжээ авах</p>	<p>Өнөөгийн байдлаар эмнэлгийн үүсгэсэн өрийг “өмчлөгч” төлдөг. Төсвийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.5-Д зааснаар СЯ нь болзошгүй өр төлбөрийн /бүртгэл, хяналт, зохицуулалт, судалгаа болон магадлал, төсвөөс гарч болох зардлын хэмжээг тооцон бүртгэж, дүгнэлт гаргах, мэдээлэх чиг үүргийг гүйцэтгэнэ. Өрийн удирдлагын тухай хуулиар өрийн асуудлыг зохицуулж байна.</p> <p>Эмнэлэгт эмийн сарын төсөв дууссан шалтгаанаар өвчтөн эмээ гаднаас худалдаж авах нь түгээмэл тохиолддог. Энэ тохиолдолд эмнэлэг ЭМД-ын тухай хуулиар иргэний худалдаж авсан эмийн зардлыг нөхөж өгөх үүрэгтэй ч өнөөг хүртэл хэрэгжихгүй байна. Харин иргэн гомдол гаргасан тохиолдолд ЭМД-ын байгууллагаас эмнэлэгт шаардлага тавьж авсан эм тарианы</p>	<p><u>Зохицуулалт:</u></p> <p>Тодорхой шалтгаанаар /өвчлөл их гэх мэт/ төсөвт дутагдал үүссэн бол жилийн эцсийг хүлээлгүй, улирал, хагас жилээр төсвийн тохируулга хийж нэмэлт төсөв авах боломжийг бүрдүүлнэ.</p> <p>Эмнэлгийн өрийн зохицуулалтад эмнэлэг өр үүсгэх зайлшгүй нөхцөл, богино хугацаат зээлээр жижиг тоног төхөөрөмж төр, хувийн хэвшлийн түншлэлээр авах, түрээслэх, урсгал засвар хийх зэрэг шийдвэрийг өмчлөгч байгууллагаас зөвшөөрөл авч гаргах хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх шаардлагатай.</p> <p>ЭМД-ын тухай хуулийн дагуу эрдслийн санг байгуулж, өвчлөлийн тоо хэмжээ өөрчлөгдсөнтэй холбоотой гарсан ЭМД-</p>

